**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АКТ**

2018 оны 02 дугаар сарын 22 № 01/24 ДУА-2018/101СТА-ОНТС Мандалговь хот

**Төлбөр барагдуулах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Дэлгэрхангай сумын Сум хөгжүүлэх сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар төсөл хэрэгжүүлэгч 27 иргэн гэрээнд заасны дагуу үндсэн зээл, зээлийн хүүг төлөлгүй хугацаа хэтрүүлснээс нийт 51,198,559 / *тавин нэгэн сая нэг зуун ерэн найман мянга таван зуун тавин есөн*/ төгрөгийн авлагыг зээлдэгч нар төлөөгүй зөрчил илэрсэн.

Энэ нь Иргэний тухай хуулийн 222 дугаар зүйлийн 222.4.-т /*Хугацаа хэтрүүлсэн үүрэг гүйцэтгэгч нь түүнд ямар нэг тохиолдол нөлөөлсөн эсэхийг харгалзахгүйгээр хохирлыг хариуцна*/, 222.5.-т /*Мөнгөн төлбөрийн үүргээ хугацаанд нь гүйцэтгээгүй бол үүрэг гүйцэтгэгч хэтрүүлсэн хугацаанд тохирсон хүү төлөх үүрэгтэй.*/, зээлдүүлэгчтэй байгуулсан "Сум хөгжүүлэх сангаас олгох зээлийн гэрээ"-ний 2.2-т /*Зээлийн үндсэн төлбөрийг дор дурдсан зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлж, дуусгана. /Хавсралт-1/*/ гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т /*Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих*/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /*Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх*/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1.7-д /*Улсад болон байгууллагад хохирол учруулсан төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан*/ гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийг эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөөгүй, хугацаа хэтрүүлсэн нийт 51,198,559 / тавин нэгэн сая нэг зуун ерэн найман мянга таван зуун тавин есөн /төгрөгийн зээлийн авлагыг нэр бүхий 27 зээлдэгч /Хавсралт 1/ нараар нөхөн төлүүлж, Дэлгэрхангай сумын Сум хөгжүүлэх сангийн Төрийн сан банк дахь 100080155406 дугаар дансанд 2018 оны 3 дугаар сарын 25-ны дотор төвлөрүүлэх;

Актыг тогтоосон хугацаанд бүрэн барагдуулах арга хэмжээ авах, биелэлтийг 2018 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт албан ёсоор ирүүлэхийг Дэлгэрхангай сумын Засаг дарга О.Батчулуун, нягтлан бодогч Б.Өрнөхбаяр, сум хөгжүүлэх сан хариуцсан мэргэжилтэн Ё.Эрдэнэбулган нарт хариуцуулав.

**АКТЫГ**

**ТОГТООСОН[1]:** **ЗӨВШӨӨРСӨН:**

АУДИТОР Д.ДОЛЖИНСҮРЭН ЗАСАГ ДАРГА О.БАТЧУЛУУН

4817144213
ЗЮА0039 9033475

НЯГТЛАН БОДОГЧ Б.ӨРНӨХБАЯР

СУМ ХӨГЖҮҮЛЭХ САН ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Ё.ЭРДЭНЭБУЛГАН

[1] *Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.*

Төрийн аудитын 2018 оны 02 сарын 22 өдрийн
01/24 дугаар төлбөрийн актын хавсралт

ЗЮА0039 9033475

# Сум сангаас хугацаа хэтрэлттэй зээлдэгчийн жагсаалт

| № | Зээлдэгчид | Дуусах огноо | Аудитлагдсан үлдэгдэл | | |
|---|---|---|---|---|---|
| | | | Үлдэгдэл | | |
| | | | Зээл | Хүү | Нийт |
| 1 | Г,Энхбат | 2016 | 4,222,562.00 | 296,813.86 | 4,519,375.86 |
| 2 | Жу,Өлзийжаргал <РД:101 | 2014 | 1,533,392.00 | 165,235.76 | 1,698,627.76 |
| 3 | М,Норовэрдэнэ <РД:101> | 2017 | 5,313,427.02 | - | 5,313,427.02 |
| 4 | М,Сансарбаатар <РД:101> | 2016 | 2,929,273.00 | 58,585.46 | 2,987,858.46 |
| 5 | М.Батсүх <РД:4> | 2014 | 879,834.00 | 17,596.68 | 897,430.68 |
| 6 | Н,Бямбасүрэн <РД:101> | 2014 | 2,160,000.00 | 390,014.00 | 2,550,014.00 |
| 7 | П,Жүгдэр | 2015 | 1,936,000.00 | 121,830.00 | 2,057,830.00 |
| 8 | Р,Түвшинчимэг | 2016 | 399,329.00 | 16,577.87 | 415,906.87 |
| 9 | С,Алтанцэцэг | 2016 | 1,311,210.00 | 57,197.30 | 1,368,407.30 |
| 10 | С,Батмөнх | 2013 | 1,400,000.00 | 84,000.00 | 1,484,000.00 |
| 11 | Х,Бальдармаа | 2015 | 2,500,000.00 | 191,336.00 | 2,691,336.00 |
| 12 | Х,Баттүвшин | 2016 | 176,250.00 | - | 176,250.00 |
| 13 | Ц,Балгансүрэн | 2016 | 200,000.00 | 6,000.00 | 206,000.00 |
| 14 | Ц,Дэлгэрсайхан | 2016 | 4,083,647.00 | 344,625.41 | 4,428,272.41 |
| 15 | Ц.Уранчимэг <РД:101> | 2017 | 1,000,000.00 | 49,299.00 | 1,049,299.00 |
| 16 | Ч,Энхбаяр | 2013 | 602,000.00 | 72,536.00 | 674,536.00 |
| 17 | Ш,Сарангэрэл | 2016 | 5,235,522.00 | 335,497.66 | 5,571,019.66 |
| 18 | Э.Соёлмаа | 2017 | 1,000,000.00 | 49,349.00 | 1,049,349.00 |
| 19 | Ю,Нэргүй | 2014 | 792,613.00 | 58,033.39 | 850,646.39 |
| 20 | Дэлгэр цагаан бошиго хорш | 2016 | 5,000,000.00 | 415,000.00 | 5,415,000.00 |
| 21 | Ю,Отгонцэцэг | | 25,219.00 | - | 25,219.00 |
| 22 | Номхонмазаалай ХХК | | - | 20,980.00 | 20,980.00 |
| 23 | Ё,Соёл-эрдэнэ | | 11,500.00 | 345.00 | 11,845.00 |
| 24 | Б,Нармандах | | 19,683.00 | 590.00 | 20,273.00 |
| 25 | Д,Саранцэцэг | | 182,393.48 | - | 182,393.48 |
| 26 | Иргэд <РД:101> | | 372,099.00 | 11,162.97 | 383,261.97 |
| 27 | МУБИС <РД:101> | | 5,000,000.00 | 150,000.00 | 5,150,000.00 |
| | Нийт | | **48,285,953.50** | **2,912,605.36** | **51,198,558.86** |